



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/07/НА/СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Б.Оюунхэрлэн

Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл... Error! Bookmark not defined.	
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	
3.1 Байгууллагын үйл ажилагаа.....	6
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	6
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	7
4. Аудитын тайлан.....	6
4.1 Ерөнхий зүйл.....	8
4.2 Дотоод хяналт.....	8
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
4.4 Материаллаг байдал	8
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	8
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	9
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	9
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	9
8. Аудитын илрүүлэлт	9
8.1 Залруулсан алдаа	9
8.2 Зөвлөмж	Error! Bookmark not defined.
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт^[Хм1]

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.03.15 № 169
танай _____ -ны № _____ -т

ДОРНОД АЙМГИЙН ГУРВАНЗАГАЛ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.БАТДЭЛГЭР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймгийн Гурванзагал сумын Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймгийн Гурванзагал сумын Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020177

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,970,097.57</u>	<u>212,407.64</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,773,397.57	15,707.64
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	1,773,397.57	15,707.64
3121	Төгрөг	1,773,397.57	15,707.64
31213	Арилжааны банк дахь харилцах	1,773,397.57	15,707.64
35	БАРАА МАТЕРИАЛ	196,700.00	196,700.00
354	Хангамжийн материал	196,700.00	196,700.00
35420	Аж ахуйн материал	196,700.00	196,700.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>209,045,507.58</u>	<u>172,469,317.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	209,045,507.58	172,469,317.00
392	Биет хөрөнгө	209,045,507.58	172,469,317.00
39201	Барилга, байгууламж, орон сууц	79,418,310.00	79,418,310.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,567,142.42)	(44,125,813.00)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	28,932,500.00	28,932,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(26,637,500.00)	(28,932,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	20,463,500.00	20,463,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(8,643,500.00)	(14,891,500.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,450,600.00	14,450,600.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,450,600.00)	(14,450,600.00)
39209	Зам, гүүрийн байгууламж	267,350,992.00	267,350,992.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(112,271,652.00)	(135,746,172.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>211,015,605.15</u>	<u>172,681,724.64</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>211,015,605.15</u>	<u>172,681,724.64</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	211,015,605.15	172,681,724.64
512	Хуримтлагдсан үр дүн	211,015,605.15	172,681,724.64
51210	Өмнөх үеийн үр дүн	238,024,014.60	211,015,605.15
51220	Тайлант үеийн үр дүн	(27,008,409.45)	(38,333,880.51)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>211,015,605.15</u>	<u>172,681,724.64</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,288,670.70	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,288,670.70	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,288,670.70	-
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	4,288,670.70	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	31,297,080.15	38,333,880.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	31,297,080.15	38,333,880.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,297,080.15	38,333,880.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,680,444.04	1,403,789.93
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	2,680,444.04	1,403,789.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	543,200.00	328,500.00
210604	Урсгал засвар	543,200.00	328,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,700.00	25,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,500.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	26,200.00	25,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,891,736.11	36,576,190.58
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	27,891,736.11	36,576,190.58
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(27,008,409.45)</u>	<u>(38,333,880.51)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(27,008,409.45)</u>	<u>(38,333,880.51)</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,024,014.60	238,024,014.60
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	238,024,014.60	238,024,014.60
C08	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	238,024,014.60	238,024,014.60
D08	Тайлант үеийн үр дүн	-27,008,409.45	-27,008,409.45
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,015,605.15	211,015,605.15
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,015,605.15	211,015,605.15
D08	Тайлант үеийн үр дүн	-38,333,880.51	-38,333,880.51
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	172,681,724.64	172,681,724.64

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>4,288,670.70</u>	=
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,288,670.70	-
120	Нийтлэг татварын бус орлого	4,288,670.70	-
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	4,288,670.70	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,448,544.04</u>	<u>1,757,689.93</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,448,544.04	1,757,689.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,448,544.04	1,757,689.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,723,644.04	1,403,789.93
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	2,723,644.04	1,403,789.93
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	543,200.00	328,500.00
210604	Урсгал засвар	543,200.00	328,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,700.00	25,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	120,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	35,500.00	
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	26,200.00	25,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>840,126.66</u>	<u>(1,757,689.93)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	840,126.66	(1,757,689.93)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	933,270.91	1,773,397.57
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,773,397.57	15,707.64

3. Санхүүгийн тайлангийн тодруулга**3.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын зорилго, чиглэлийг сумын нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, засвар үйлчилгээ явуулна гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны 12 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн “Орон нутгийн өмчийн талаархи иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх” 77.2.4 дэх “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн

байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна..

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд сумын удирдлагаас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлтүүд ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,773.4	15.7	-1,757.7
Авлага	-	-	-
Бараа материал	196.7	196.7	-
Үндсэн хөрөнгө	209,045.5	156,903.7	-52,141.8
Нийт хөрөнгийн дүн	211,015.6	157,116.1	-53,899.5
Өр төлбөрийн дүн	-	-	-
Эздийн өмч	211,015.6	157,116.1	-53,899.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	211,015.6	157,116.1	-53,899.5

Банкин дахь харилцах дансанд 15.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгөд өөрчлөлт ороогүй, тайлант оны элэгдэл 52.1 сая төгрөг байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулаагүй байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж, аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар хэрэгжүүлсэн.

Гурванзагал сумын Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь дотоод хяналтын нэгжгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Санхүүгийн хяналт аудитын албанаас 2021 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт хөрөнгийн 211.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, тайлант оны нийт хөрөнгийн 1 хувиар буюу 1.5 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн дагуу мэдээллийг бүрэн байршуулсан байна.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлыг өөрчилсөн талаар тушаал шийдвэр гаргаагүй, удирдлагыг дахин томилоогүй, үйл ажиллагааг хэвийн явуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь "Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 78.2.2 дахь "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох", 78.2.7 дахь "нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудтай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх онд түүвэрт хамрагдсан байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаашид байгууллагын үйл ажиллагаагаа хэвийн явуулах талаар арга хэмжээ авч ажиллах.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар 15.5 сая төгрөгийн зөрчил илрүүлж, залруулга хийсэн.

8.1 Залруулсан алдаа[хм2]

Тавилга, аж ахуйн эд хогшлын элэгдлийг 15.5 сая төгрөгөөр илүү тооцоолсныг аудитын явцад залруулсан.

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
ДҮН																
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Гурванзагал хөгжил ОНӨААТҮГ	ДОА-2022/11НА/СТА-ОНА	1. Гүйцэтгэх захирлыг өөрчилсөн талаар тушаал шийдвэр гаргаагүй, удирдлагыг дахин томилоогүй, ажиллагааг хэвийн явуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй 2. Элэгдлийн зардал буруу тооцоолсон	1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2 дахь "Хуульд өөрөөр заагаагүй бол Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 78.2.2 дахь "орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эрх баригчийг томилох", 78.2.7 дахь "нутгийн өмч эрхэлсэн ажилтан буюу албыг шуурхай удирдах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах 2. Үндсэн хөрөнгийн элэгдлийг илүү тооцоолсон	2	15,565.6	1	15,565.6					1	-		
ДҮН																
					2	15,565.6	1	15,565.6					1			